



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
сургуулийн биеийн тамирын багш нарт
зориулсан сургалтыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нарт зориулсан сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах 6,445,000 (зургаан сая дөрвөн зуун дөчин таван мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын "Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих зардал"-аас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дүгээр тушаалын хавсралт



Нийслэлийн Ерөнхий боловсролын
сургуулийн биеийн тамирын багш нарт
сургалтыг зохион байгуулахад
шаардагдах төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.	Багшийн ажлын зардал	3 өдөр х 8 цаг	80,000	1,920,000
2.	Заал талбайн зардал	3 өдөр	500,000	1,500,000
3.	Лед дэлгэцний түрээс	3 өдөр	500,000	1,500,000
4.	Цай кофены зардал	125 хүн	8,000	1,000,000
5.	Батламж хэвлүүлэх зардал	125 хүн	3,000	375,000
6.	Хулдаасан хэвлэлийн зардал	12м2	12,500	150,000
Дүн				6,445,000